<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Давтан сургалт сэргээн заслын төв нэг зуун арван гуравдугаар ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд өөрийн орлогын төлөвлөгөө биелээгүй, авлага үүсгэсэн, үндсэн хөрөнгийн элэгдэл алдаатай тооцсонтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2021 оны 11 дүгээр сарын 01-наас 2022 оны 2 дугаар сарын 15-ны хооронд Цэгцтөв богд аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Цэцэгмаа, аудитор Б.Баярмаа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Өлзий-Орших, захирал Н.Цэрэнханд нар хэрэгжүүлсэн.

Давтан сургалт сэргээн заслын төв 113 дугаар ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 16/13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Давтан сургалт сэргээн заслын төв 113 дугаар анги нь олон улсын жишигт нийцсэн, нийгмийн хөгжлийн шаардлагыг хангасан мэргэжилтэн бэлтгэх, амралт сувиллын таатай орчинг бүрдүүлэн, үйлчлүүлэгчдээ дээдлэн, ажилтан бүрийнхээ амжилтаар бахархах манлайлагч хамт олон байх эрхэм зорилгын хүрээнд эмчилгээ, үйлчилгээндээ дэвшилтэт технологи нэвтрүүлэх, эмнэлэгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын тохиолдолгүй ажиллаж Ковид-19 цар тахалын үед иргэдийг тусгаарлах, хөнгөн, хүндэвтэр өвчтөнд эмчилгээ үйлчилгээ үзүүлэх, өвчлөөд эдгэрсэн иргэдэд сэргээн засах үйлчилгээг хүртээмтэй үзүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаанд, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага Онцгой байдлын ерөнхий газрын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрддөг, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Онцгой байдлын ерөнхий газрын хяналт үнэлгээ, дотоод аудитын газраас дотоод хяналт шалгалт төлөвлөгдөөгүй, хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.



### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Давтан сургалт сэргээн заслын төв 113 дугаар ангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,101,818.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 21018.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж суурь үзүүлэлтээр тооцсон өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тайлант оны зардал 886,707.2 мянган төгрөг буюу 58.1 хувиар өссөн тул дахин тооцох шаардлагатай гэж үзлээ.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,413,196.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 24,131.9 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Давтан сургалт сэргээн заслын төв 113 дугаар ангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 667,826.1 мянган төгрөгөөр буюу 9.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн дансууд байна.

/мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	740,416.8	0.00	(740,416.8)
Авлага	5,607.0	23,306.5	21,699.5
Урьдчилж төлсөн зардал	1,337.7	-	1,337.7
Бараа материал	798,820.9	541,578.4	(257,242.5)
Үндсэн хөрөнгө	5,438,315.4	7,083,439.0	1,645,123.6
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,984,497.8</b>	<b>7,652,323.9</b>	<b>667,826.1</b>
Богино хугацаат өр төлбөр	623,540.5	79,762.5	(543,778.0)
Засгийн газрын хувь оролцоо	6,360,957.3	7,572,561.4	1,211,604.1
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>6,984,497.8</b>	<b>7,652,323.9</b>	<b>667,826.1</b>

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны өмнөх оны үлдэгдлээс 507,145.8 мянган төгрөгийг ОБЕГ-ын харъяа онцгой хувцас хэрэглэл, туршилт үйлдвэрлэлийн төв 121 дүгээр ангийн дансанд, 225,438.4 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн;
- Авлага данс ЭМДС-аас оны эцэстшилжүүлсэн 21,750.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлснээс авлага нэмэгдсэн;
- Бараа материал данс Онцгой хувцас хэрэглэл, туршилт үйлдвэрлэлийн төвд бараа материалын үлдэгдэл 257,242.5 мянган төгрөгийг шилжүүлснээс;
- Үндсэн хөрөнгө ОБЕГ-аас хөдөлгөөнт эмнэлэгийн тусгай тоноглол бүхий 1,711,969.3 мянган төгрөгийн үнэтэй автомашин үнэ төлбөргүй хүлээн авсан, 36,670.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж худалдан авсан, Онцгой байдлын харъяа анги байгууллагад 33,647.0 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг шилжүүлсэн, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 32,174.0 мянган төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг акталж устгасан, үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулсан зэргээс нэмэгдсэн;
- Өр төлбөр: Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 2021 оны 11, 12 дугаар сарын сувиллын үйл ажиллагааны санхүүжилтийн орлого тасарснаас байгууллагад төлөх өр төлбөр 63,433.6 мянга, татварын байгууллагад 15,788.4 мянга, хувь хүмүүст 40.4 төгрөгийн өглөг үүссэн;

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөгө болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Давтан сургалт сэргээн заслын төв 113 дугаар ангийн 2021 оны санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсвөөс 1,012,147.2 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлогоос 598,307.8 мянган төгрөг нийт 1,610,455.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвөөс санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,664.1 мянган төгрөгөөр бууруулан нийт 1,608,790.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд Короновируст халдвар цар тахалын үед тусгай үүргийн онгоцоор хилийн чанадаас ирсэн иргэдийг тусгаарлах үйл ажиллагааг явуулж эхэлснээр тусгаарлалтанд ажиллаж байгаа ажилчдад нэг удаагийн урамшил олгох болон бусад арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилтийг нэмж тодотгох хүсэлт тавьж шийдвэрлүүлснээс шалтгаалж батлагдсан төсвөөс 182,180.0 мянган төгрөгөөр нэмж төсвийг тодотгон 1,790,970.9 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг Улсын төсвөөс 1,192,663.1 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагаанаас 598,307.8 мянган төгрөг, нийт 1,790,970.9 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төсөвлөн, гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн авч, өөрийн үйл ажиллагааны орлогоос 429,566.9 мянган төгрөг, нийт 1,622,230.0 мянган төгрөгийг зарцуулж 90.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	код	нэр				

1	70207	Гамшгаас урьдчилан сэргийлэх	1,790,970.9	1,622,230.0	168,740.9	90.6
1.1	80101	Үндсэн үйл ажиллагаа	1,788,970.9	1,620,230.8	168,740.1	90.6
1.2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	2,000.0	1,999.2	0.8	99.9
1.3	82705	Нэмэлт үйл ажиллагаа		563,394.6	563,394.6	0.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээрэнэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчийн төсвөөс барилгын гадна шилэн фасадны засварт зориулан доод шатны төсвийн захирагчид хуваарилсан 277,096.2 мянган, Эрүүл мэндийн яамнаас эмнэлэгийн ажилтанд олгох нэг удаагийн урамшуулалд 48,000.0 мянган, үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 238,298.4 мянган нийт 563,394.6 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлжээ.

Үүнээс гамшгийн үеийн томилолтын зардалд 90,956.0 мянган, Улсын онцгой комиссын шуурхай штабын бүрэлдэхүүний хоолны зардалд 186,140.2 мянган, эмнэлэгийн ажилтанд олгох нэг удаагийн тэтгэмжид 48,000.0 мянган гадна фасадны гэрээний төлбөрт 238,298.4 мянган нийт 563,394.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Давтан сургалт сэргээн заслын төв 113 дугаар анги нь өөрийн үндсэн үйл ажиллагааг 11-12 сард явуулж бусад хугацаанд Короновируст халдвар Ковид-19 цар тахалын үеийн онцгой үүрэг гүйцэтгэсэн, ажлын байрны гадна фасадын их засвар явагдаж өөрийн орлого бүрдэх боломжгүй байжээ.

Тайлант онд байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 90.6 хувийн биелэлттэй, 9.4 хувь буюу 168,740.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Монгол Улсын ерөнхий аудиторын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/111 дүгээр тушаалаар баталсан Ерөнхий чиглэл, аргачилсан зөвлөмжийн дагуу гаргасан судалгааг шалгагдагч байгууллагаар гаргуулан хянаж аудитдаа ашигласан болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахалыг эмчлэн сувилах үйл ажиллагаа явуулж байгаа энэ цаг үед Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт хугацаандаа олгогдоогүй, зарцуулах боломжгүй буцаан төвлөрүүлж байгаа нь авлага үүсэх, орлогын төлөвлөгөө тасрах, гэрээт байгууллагад өглөг үүсгэх гол асуудал болсон байна.

### 3.9 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн, 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Давтан сургалт сэргээн заслын төв 113 дугаар анги нь нийт 131,965.7 мянган төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 419.0 мянган төгрөгийн 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах, албан шаардлага хүргүүлэх

#### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 12,730.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 4 зөвлөмж өгч жилийн эцсийн аудитаар дахин хянахад өгсөн зөвлөмжийг бүрэн биелүүлсэн байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 67,000.0 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн биелэлт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	67,000.0	2	67,000.0			100
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>67,000.0</b>	<b>2</b>	<b>67,000.0</b>	<b>2</b>		<b>100</b>

#### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татах асуудал гараагүй болно.

#### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 32,828.4 мянган төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс, 12,730.9 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 17,086.7 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3,010.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 4 алдаа, зөрчлийн дүн 20,097.5 мянган төгрөг нь тогтоосон материаллаг байдал 24,131.9 мянган төгрөгөөс хэтрээгүй тул “Зөрчилгүй дүгнэлт” өглөө.

##### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Анхан шатны И баримтгүй гүйлгээг бүртгэлд тусгасан 1,266.1 мянган төгрөг,
- Авлага дансны үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй 2,630.3
- Ашиглалтад тавьж олгосон хөдөлмөр хамгаалалтын хувцасыг нийт үнийн дүнгээр зардалд бүртгэсэн 8,834.5 мянган төгрөг

##### **4.2 Албан шаардлага**

Тайлант хугацаанд 5 байгууллагатай холбоотой 5,556.5 мянган төгрөгийн авлага, 5 байгууллагатай холбоотой 11,530.1 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үүссэн авлага, өр төлбөрийг барагдуулах, авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах Албан шаардлага хүргүүлэх

##### **4.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

###### **1. Дотоод хяналттай холбоотой асуудал**

###### Илрүүлэлт:

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 145,600.0 мянган төгрөгөөр дутуу биелэлттэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 4.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Орлогын төлөвлөгөөг биелүүлэн Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэхь заалтыг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх

###### **2. Дотоод хяналттай холбоотой асуудал**

###### Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулах жилийг алдаатай тооцож үндсэн хөрөнгийн элэгдэл 3,010.9 мянган төгрөгийг зардалд илүү тусгасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж тус тус заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

ОБЕГ-ын бодлогын баримт бичигт зааснаар ашиглалтын хугацааг байгууллага өөрөө тодорхойлон баталж, хөрөнгийн элэгдлийг байгуулан бүртгэлд тусгах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянгантөгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс									
							Залруулга		Төлбөр акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн аудитын асуудал</b>																
1	ДССЗТ-113-р анги	АХГ-2022 /169/ НА-СТА-ТШЗ	Анхан шатны И баримтгүй гүйлгээг бүртгэлд тусгасан	И баримтыг бүрдүүлж баримтжуулах	1	1,266.1	1	1,266.1								
2	ДССЗТ-113-р анги	АХГ-2022 /169/ НА-СТА-ТШЗ	Нормын хувцасыг нийт үнийн дүнгээр шууд зардалд тусгасан	Стандартын дагуу урьдчилж төлсөн зардлаар бүртгэж, элэгдлийн нормоор зардалд тусгах	1	8,834.5	1	8,834.5								
3	ДССЗТ--	АХГ-2022 /169/ НА-СТА-ТШЗ	Авлагын үлдэгдэл тооцоо нийлж баталгаажуулаагүй	Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах	1	2,630.3	1	2,630.3								
4	ДССЗТ-113-р анги	АХГ-2022 /169/ НА-СТА-ТШЗ	Санхүүгийн тайлангийн засгийн газрын хувь оролцоо хэсэгт эздийн өмч тусгаагүй	Өмчийг бүртгэлд тусгаж харуулах	1		1	0.00								
5	ДССЗТ-113-р анги	АХГ-2022 /169/ НА-СТА-ТШЗ	Авлага үүсгэсэн	Авлага барагдуулах давтан гахгаргүй байх	5	5,556.5					1	5,556.5				
6	ДССЗТ-113-р анги	АХГ-2022 /169/ НА-СТА-ТШЗ	Өглөг үүсгэсэн	Өглөг барагдуулах давтан гаргахгүй байх	5	11,530.1					1	11,530.1				
7	ДССЗТ-113-р анги	АХГ-2022 /169/ НА-СТА-ТШЗ	Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө тасарсан	Орлогын төлөвлөгөөг ханган биелүүлж ажиллах	-	-									1	0.00
8	ДССЗТ-113-р анги	АХГ-2022 /169/ НА-СТА-ТШЗ	Үндсэн хөрөнгийн элэгдэл алдаатай байгуулсан	Үндсэн хөрөнгийн элэгдлийн хугацааг тогтоож мөрдөх	1	3,010.9									1	3,010.9
<b>Санхүүгийн тайлангийн аудитын алдаа зөрчлийн дүн</b>					<b>8</b>	<b>32,828.4</b>	<b>4</b>	<b>12,730.9</b>			<b>2</b>	<b>17,086.6</b>			<b>2</b>	<b>3,010.9</b>
<b>Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийцлийн аудитын асуудал</b>																
9	ДССЗТ-113-р анги	АХГ-2022 /169/ НА-СТА-ТШЗ	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг ил тод бүрэн айршуулаагүй	Шилэн дансны хуулинд ил тод мэдээлэхээр заасан мэдээллийг бүрэн байршуулах	1	419.0					1	419.0				
<b>Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийцлийн аудитын алдаа зөрчлийн дүн</b>					<b>1</b>	<b>419.0</b>					<b>3</b>	<b>419.0</b>				
<b>НИЙТ ДҮН</b>					<b>9</b>	<b>33,247.4</b>	<b>4</b>	<b>12,730.9</b>			<b>3</b>	<b>17,505.6</b>			<b>2</b>	<b>3,010.9</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 121/А0150058  
АХГ-2022/169/НА-СТА-ТМС  
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Давтан сургалт, сэргээн заслын төв 113 дугаар ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Харилцагч 5 байгууллагатай холбоотой 5,556,500.00 төгрөгийн авлага, 11,530,147.50 төгрөгийн өр төлбөр нийт 17,086,647.50 төгрөгийн авлага, өр төлбөр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Авлага, өр төлбөр үүсгэсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ангийн захирагч дэд хурандаа Ц.Уранчимэг, ахлах нягтлан бодогч ахмад Х.Цолмон нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ  
Г.ЦЭЦЭГМАА







ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 120/А.0150058  
АХГ-2022/1169/НБ/СТА-ТМЗ  
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Давтан сургалт, сэргээн заслын төв 113 дугаар ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 419,000.00 төгрөгийн 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг ил тод, хуулийн хугацаанд бүрэн байршуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Давтан сургалт сэргээн заслын төв нэг зуун арван гуравдугаар ангийн захирагч дэд хурандаа Ц.Уранчимэг, ахлах нягтлан бодогч хошууч Х.Цолмон нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

ЦНАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ  
ЦЭЦЭГМАА